

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 16-ны өдөр

№ 06/2022

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх заалт, 71 дүгээр 71.1, 71.3, 71.4 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалтууд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг үндэслэн компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. “БидиСек ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4 сарын 25-ны өдөр 10 цагт Улаанбаатар хотод цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - а) Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, аудитлагдсан санхүүгийн тайланг хэлэлцэж, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах;
 - б) Ногдол ашиг тараах тухай шийдвэрийг танилцуулах;
 - с) ТУЗ-ийн 2022 оны төсвийг батлах;
 - д) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2022 оны 03 сарын 21-ний өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2022 оны 04 сарын 05-ны өдөр дахин зар гаргахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2022 оны 3 сарын 21-ны өдрөөс 2022 оны 04 сарын 24-ний өдөр хүртэл 09⁰⁰-18⁰⁰ цагийн хооронд "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн байранд ирж танилцах, и-мэйлээр авах эсвэл харьяалагдах Үнэт Цаасны Компаниас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 1 хоногийн өмнө мөн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчээс санал хүлээн авахаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар С.Дөлгөөн, гишүүнээр Э.Эрхэмзаяа, Б.Ингүүнзаяа, М.Зулсар нарыг тус тус томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Компанийн Тэргүүн Дэд захирал Б.Лхагвадорж, тооллогын комиссын даргаар "БиДиСек ҮЦК" ХК-ийн мэргэжилтэн А.Өлзиймаа, гишүүнээр "БиДиСек ҮЦК" ХК-ийн мэргэжилтэн С.Халиун нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/